

2019 ОНД ИМПОРТЛОХ СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Шалгаруулалтын дугаар: СХЭИЗОСШ-20190312

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 77 дугаар тогтоолоор баталсан “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журам”-д заасны дагуу 2019 онд импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо, хэмжээнд багтаан зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зарлаж байна. Үүнд:

Үрийн улаанбуудай - 10000 тн /арван мянга/

Оролцогч нь дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, битүүмжлэн 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 16 цаг 00 минутаас өмнө Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны 504 тоот өрөөнд бүртгүүлж, хүлээлгэн өгнө. Үүнд:

1. Импортлох хүнсний нэр төрөл, тоо хэмжээг заасан албан бичиг;
2. Хуулийн этгээдийн нэр, байршил, хаяг, утас, факсын дугаар, цахим хаяг;
3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, эрхэлж байгаа хүнсний чиглэлийн үйл ажиллагаан төрөл, хэлбэр;
4. Татварын өргүй болохыг тодорхойлсон харъяалах татварын албаны тодорхойлолт;
5. Аудитаар баталгаажсан 2018 оны санхүүгийн тайлан;
6. Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан зориулалтын агуулах, тээврийн хэрэгсэлтэй эсэхийг нотлох баримт бичиг, эсхүл энэ шаардлагыг хангасан агуулахыг түрээслэх тухай хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний нотариатаар баталгаажуулсан хувь;
7. Экспортлогч улсын импортлох бүтээгдэхүүнд олгосон гарал үүслийн болон чанарын гэрчилгээ, шинжилгээний дүн;
8. Экспортлогч улсын үйлдвэр эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан худалдааны гэрээ;
9. Хуулийн этгээдийг төлөөлөн сонгон шалгаруулалтад оролцох этгээдийн итгэмжлэл бүхий албан бичиг.

Сонгон шалгаруулалтад оролцогчийн материалыг хүлээн авах эцсийн хугацаа: 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 16 цаг 00 минут /Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахгүй/

Сонгон шалгаруулалтыг нээх хугацаа: 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 17 цаг 00 минут

ХАЯГ:

Монгол Улс, Улаанбаатар-13381, Энхтайваны өргөн чөлөө 16а,
Засгийн газрын 9 дүгээр байр, Б корпус, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
яамны
5 давхарт, 504 тоот өрөө, Утас: 261962